

**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН ТЕХНИКИЙН
БОЛОВСРОЛ ОЛГОХ СУРГАЛТАД СУРАЛЦАГЧИЙН ТӨГСӨЛТИЙН АЖИЛ
ХАМГААЛУУЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Техникийн боловсрол олгох ангийн төгсөгчдийн төгсөлтийн ажил гүйцэтгэх, хамгаалалтыг нэгдсэн удирдлагаар хангахад энэхүү журмыг баримтлан зохион байгуулна.

1.2 Мэргэжлийн багууд бэлтгэж буй мэргэжлийн чиглэл бүрээр төгсөлтийн ажлын агуулга, хэмжээ, тавигдах үндсэн шаардлагуудыг тусгасан аргачилсан зааврыг боловсруулан, сургалт арга зүйн зөвлөлөөр хэлэлцүүлэн мөрдөнө.

Хоёр. Төгсөх оюутны бүртгэл, сургалтын төлбөр

2.1. Сургалтын алба доорх шаардлагыг хангасан оюутныг төгсөх оюутнаар бүртгэнэ.

2.1.1. Сургалтын төлөвлөгөөний дагуу авбал зохих кредитийг бүрэн цуглуулсан байх,

2.1.2. Үйлдвэрлэлийн дадлагын тайланг хамгаалж тэнцсэн байх

2.1.3. Сургалтын төлбөрийн үлдэгдэлгүй байх(төлбөрийг улиралд хуваан төлсөн байж болно)

2.1.4. Өөрийн сургуулиас шатлан суралцаж буй суралцагчийн төлбөрийг уян хатан зохицуулах, ур чадварын уралдаан тэргүүлсэн бол үнэ төлбөргүй суралцах

Гурав. Төгсөлтийн ажлын зохион байгуулалт

3.1. Төгсөлтийн ажил нь 2 хэлбэрээр зохион байгуулагдаж болно.

А/. Төгсөлтийн диплом бичих

Б/. Төгсөлтийн шалгалт өгөх(онол, ур чадвар)

3.2. Төгсөгч нь төгсөлтийн ажил хийх сэдэв, даалгаврын талаар мэргэжлийн баг, удирдагч багштай ярилцаж сургалтын албаар баталгаажуулсан байна.

3.3. Төгсөлтийн ажлын бэлтгэл, удирдлага, зохион байгуулалтыг мэргэжлийн баг хариуцах бөгөөд мэргэжил бүрийн онцлогт тохирсон төгсөлтийн ажил хийх аргачилсан зааврыг боловсруулж, төгсөгч бүрт танилцуулсан байна.

3.4. Төгсөлтийн ажил нь онолын болон ур чадварын шалгалт, биет бүтээл, тайлбар бичиг, технологийн зураг байж болно.

3.5. Төгсөлтийн ажлыг удирдагч багш сэдэв, биет бүтээлээс хамааруулж ганцаарчлан болон бүлгээр хийх асуудлыг сургалтын албатай ярилцаж урьдчилан боловсруулсан байна.

3.6. Төгсөлтийн ажлыг хийх графикт хугацаа болон төгсөлтийн ажлыг удирдагч багшийг улирлын 6 дахь долоо хоногт захирлын тушаалаар баталгаажуулна.

3.6. Төгсөлтийн ажлын явцын үзлэг, төгсөлтийн хамгаалалтын үнэлгээний хуудас, дэгийг сургалтын алба боловсруулан мэргэжлийн баг арга зүйгээр ханган батлагдсан хуваарийн дагуу төгсөлтийн ажлыг зохион байгуулна.

Дөрөв. Төгсөлтийн ажилд өгөх үнэлгээ

4.1. Төгсөлтийн ажлын явцын үзлэгийг мэргэжлийн багууд 3-аас доошгүй удаа зохион байгуулна.

4.2. Төгсөлтийн ажлын төслийг 100 оноогоор үнэлэх бөгөөд удирдагч багшаас 50 хүртэл, төгсөлтийн комиссын хамгаалалтаар 50 хүртэл оноог тус тус авна.

4.3. Удирдагч багшийн үнэлгээ:

4.3.1. Удирдагч багш оюутны тайлан, бүтээлд тавигдах үндсэн шаардлагыг хэрхэн хангаж байгаад явцын үнэлгээ 50 хүртэлх оноог өгнө.

4.3.2. Багш ямар шалгуураар үнэлэхдээ тодорхойлж тухайн мэргэжлийн баг дээр зөвшилцсөн байна. Удирдагч багш урьдчилсан хамгаалалтаас долоо хоногийн өмнө төгсөлтийн ажлын үнэлгээг тодорхойлолтын хамт комиссын нарийн бичгийн даргад хүргүүлнэ.

4.4. Комиссын гишүүдийн үнэлгээ:

4.4.1. Төгсөлтийн хамгаалалтыг захирлын тушаалаар томилогдсон комисс явуулна.

4.4.2. Комиссын гишүүн бүр төгсөлтийн ажлын төслийн болон төгсөж буй оюутны суралцсан мэргэжлийн сургалтын төлөвлөгөөний хүрээнд асуулт тавьж хамгаалалт, асуултад хариулсан байдал, удирдагч багшийн тодорхойлолт зэргийг үндэслэн дипломын төслийн хамгаалалтыг 50 хүртэл оноогоор дүгнэх бөгөөд комиссын хурлаар дүнг ахиулах буюу бууруулж болно.

4.4.3. Төгсөлтийн шалгалт нь онол 30%, ур чадвар 70% байхаар үнэлгээний материалыг боловсруулан нийт 100%-иар дүгнэнэ.

4.5. Төгсөлтийн ажлын хамгаалалтад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас орж чадаагүй, төгсөлтийн хамгаалалтад ороод 70 (С)-ээс доош хангалтгүй үнэлгээ авсан тохиолдолд оюутны өргөдөл болон холбогдох баримт нотолгоог үндэслэн төгсөлтийн хамгаалалтыг дахин зохион байгуулах эсэхийг комисс шийдвэрлэнэ.

4.6. Сургалтын алба нь тогтоолыг үндэслэн, нэр бүхий төгсөх оюутанд захирлын тушаалаар техникийн боловсролын дипломыг төгсөлтийн хамгаалалтын сүүлийн өдрөөс хойш ажлын 10 хоногт багтаан олгоно.

4.7. Диплом алдаатай хэвлэгдсэн болон үрэгдүүлсэн тохиолдолд буруутай этгээд хариуцлага хүлээнэ.